

## МУЗЕЙН ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Музейн дэргэд орон тооны бус олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.1.1. Олон нийтийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэнэ/ музейн үйл ажиллагааны чиглэлийн тогтвортой хөгжлийг дэмжих санал оруулах, иргэд, олон нийтийн байгууллагын идэвх санаачилгыг дэмжих, музейн нийгэмд гүйцэтгэх үүрэг, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор музейн захирлын дэргэд байгуулагдана.

1.1.2. Зөвлөл нь Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Музейн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, дэмжлэг үзүүлнэ.

### Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Музейн захиргааны зөвлөл олон нийтийн зөвлөлийг байгуулна.

2.2. Зөвлөл 6-9 гишүүнтэй байх бөгөөд музейн захирал, эрдэмтэд, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллийг оролцуулна.

2.3. Зөвлөлийн хуралдаанаар дарга, нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэн сонгоно.

2.4. Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

2.5. Зөвлөлийн хуралдааны шийдвэрээр гишүүдийн бүрэн эрх дараах тохиолдолд цуцлагдана:

2.5.1 зөвлөлөөс гарах тухай зөвлөлийн даргад хаяглан бичгээр өргөдөл гаргасан;

2.5.2. зөвлөлийн ажилд 3 сараас дээш хугацаагаар оролцоогүй;

2.5.3. зөвлөлийн дүрмийг зөрчсөн тохиолдолд.

2.6. Зөвлөлийн бүрэлдэхүүн 3.2-т зааснаас цөөн болсон тохиолдолд ажлын 30 хоногийн дотор шинэ нэр дэвшигчийг зөвлөлд санал болгоно.

### Гурав. Зөвлөлийн чиг үүрэг

3.1. Зөвлөл олон нийтийг төлөөлөн дараах чиг, үүргийг гүйцэтгэнэ:

3.1.1. Музейг олон нийттэй холбох, музейн нөлөөллийг өсгөх, сайжруулахад чиглэсэн хөтөлбөр, төсөл санаачлан хэрэгжүүлэх;

3.1.2. Музейн нийгэм эдийн засгийн хөгжлийн хамгийн чухал асуудлуудыг шийдвэрлэх явцыг дэмжих, музейн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах;

3.1.3. Музейн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зохих зөвлөмжийг боловсруулж батлах;

3.1.4. Үндэсний, улсын, бүс нутгийн хэмжээнд нийгэм, соёлын хүрээнд музейд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн холбоодыг татах;

3.1.5. Музейн бүрэн эрхийн хүрээнд иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон нийтийн болон иргэний нийгмийн санаачилгыг сурталчлах, дэмжих;

3.1.6. Үндэсний, улсын, бүс нутгийн хууль тогтоомж, энэхүү журмын дагуу музейн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх.

3.1.7. Музей ба зөвлөлийн саналыг үндэслэн музейн үйл ажиллагаа сайжруулах төлөвлөгөө боловсруулах.

#### **Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагаа**

4.1. Зөвлөл гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна.

4.1.1. Зөвлөл нь музейн нэг жилийн гүйцэтгэлийн төлөвлөлт, урт, богино хугацааны маркетингийн төлөвлөгөөтэй уялдан үйл ажиллагаагаа явуулах;

4.1.2. Музейн үйл ажиллагааны чиглэлээр иргэд, олон нийтийн холбоо, хуулийн этгээд, төрийн байгууллагуудын санал, санаачилгыг хүлээн авч холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.1.3. Төрийн бусад байгууллага, орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэд байгуулагдсан олон нийтийн зөвлөлтэй харилцан ажиллах;

4.1.4. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг музейтэй зөвшилцсөний дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

4.1.5. Музейн зорилго, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд музейн захиралтай зөвшилцсөнөөр музейн нөлөөллийг өсгөх арга хэмжээнд оролцох.

4.1.6. Хуралдаан дээр музейн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хөгжлийн хэтийн төлвийн талаар музей, түүний салбар нэгжийн дарга нарын мэдээллийг сонсох;

4.1.7. Зөвлөл үйл ажиллагааныхаа хүрээнд тухайн нутгийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын амьдралд музейн гүйцэтгэх үүрэг, иргэдийн оюун санааны хөгжил, нийгэм дэх музейн дүр төрхийг бий болгоход сурталчлах;

### **Тав. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр**

5.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр Зөвлөлийн хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ байна;

5.2. Зөвлөлийн нэгдсэн хуралдааныг жилд хоёроос доошгүй удаа хийх ба гишүүдийн гуравны хоёр хувь орлцсоноор хүчинтэйд тооцно;

5.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга санал болгон музейн захиралтай зөвшилцөнө;

5.4. Зөвлөл хэлэлцэж буй асуудлаар гишүүдийн олонхын нээлттэй санал хураалтаар шийдвэр гаргана.

5.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадаагүй Зөвлөлийн гишүүн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан саналаа хүргүүлсэн тохиолдолд түүнийг хуралдаанд оролцсонд тооцно.

5.6. Зөвлөл гүйцэтгэсэн ажлын тайлангаа жилд нэг удаа Музей болон олон нийтэд ил тод, нээлттэй танилцуулан, хэлэлцүүлнэ.

5.7. Зөвлөлийн шийдвэр нь бичгэн хэлбэрээр үйлдэн баталгаажуулсан зөвлөмж байна.

5.8. Зөвлөлийн үйл ажиллагааны мэдээлэл ил тод байна.

5.9. Музейн санаачилгаар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж болно.

5.10. Музейн захирал, түүнийг эзгүй тохиолдолд дэд захирал зөвлөлийн хуралдаанд санал өгөх эрхтэй оролцох ба музейн ажилтнууд, хэлэлцэх асуудалтай холбоотой хүмүүсийг зөвлөлийн хуралдаанд урьж болно.

### **Зургаа. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга**

#### **гишүүний бүрэн эрх**

6.1. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн Монгол Улсын хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа баримтлан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.1.1. Зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган тэргүүлэх чиглэлийг тодорхойлно;

6.1.2. Зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудлыг баталж хуралдааныг зохион байгуулна;

6.1.3. Музейтэй зөвшилцөн олон нийтийн төлөөлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах харилцааг зохион байгуулна;

6.2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.2.1.Зөвлөлийн даргын үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина;

6.2.2.Зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудал, холбогдох материалыг бүрдүүлж, батлуулахаар хүргүүлнэ;

6.2.3.Зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудал, материалыг гишүүдэд илгээж, хуралдааны тэмдэглэл хөтлөн, үйл ажиллагааны талаар гишүүдэд мэдээлнэ;

6.2.4. Зөвлөлийн даргыг эзгүй тохиолдолд зөвлөлийн үйл ажиллагааг орлогч дарга удирдан чиглүүлнэ.

6.3. Зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.3.1. Зөвлөлийн ажилд оролцох, төлөвлөгөөт бус зөвлөлийн хуралдааныг санаачлах;

6.3.2.Зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудлын талаар санал оруулах, зөвлөлийн хуралдаанд мэдээлэл хийх;

6.3.3.Зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудлын хэлэлцүүлэгт оролцох, тэдгээрийн талаар санал гаргах;

6.3.4.Зөвлөлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулах асуудлын холбогдох бичиг баримттай танилцах, боловсруулах шатанд санал оруулах;

6.3.5.Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийн хэрэгжилтийн талаар амаар болон бичгээр мэдээлэл авах;

### **Долоо. Музейн захирлын эрх, үүрэг**

7.1.Музей нь Зөвлөлтэй хамтрах дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.1.1. Хуулиар хамгаалагдсан нууцад хамаарах мэдээллээс бусад өөрт оногдсон чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, материал, баримт бичгийг Зөвлөлд гаргаж өгөх;

7.1.2. Зөвлөл үйл ажиллагаагаа хэвийн явуулах мэргэжлийн зөвөлгөө өгөх;

7.1.3. Зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах танхим, техник хэрэгслээр ханган, хүн хүчний тусламж үзүүлэх;

7.1.4. Музейн захирал Зөвлөлийн гишүүнээр ажиллан, музейн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд саналаа илэрхийлэн хамтран ажиллах.

### **Найм. Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх**

8.1.Аливаа хуулийн заалтыг зөрчин ёс зүйн хариуцлага хүлээж байгаагүй, төрт ёс, соёл, зан заншил, уламжлалаа эрхэмлэн дээдэлдэг, энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн, ажиллах хүсэл эрмэлзэл, сонирхол, туршлагатай, музей болон олон нийтийн эрх ашгийг илэрхийлэх Монгол улсын иргэнийг музей санал болгосноор Зөвлөлийн дарга, гишүүнээр томилно;

8.2. Зөвлөлийн гишүүний бүрэн хугацаа дуусгавар болохоос өмнө дараах үндэслэлээр чөлөөлнө.

8.2.1. Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

8.2.2. Гэм буруутай нь хууль, шүүхийн байгууллагаар тогтоогдсон.